БАТЛАВ
ХОНГОР СУМЫН
ЗАСАГ ДАРГА Н.ГАНБААТАР

Ногоон байгууламжид худаг гаргах
/Хонгор сум, Буурал баг/

2026 он Хонгор сум

№	НЭР ТӨРӨЛ, ҮЗҮҮЛЭЛТ	ШААРДЛАГА
1	Материал	Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй байна. Материалд лабораторийн туршилт шинжилгээ хийгдсэн байна.
2	Стандарт	Бараа материал нь олон улсын хэмжээнд болон, техникийн баримт бичгийн үндсэн бүрдэл хэсэг болох манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилгын норм ба дүрэм, стандарт, техникийн нөхцлийг нэг бүрчлэн баримталж ажиллана.
3	Байршил	Дархан-Уул, Хонгор сум, 1-р баг, Ногоон байгууламжид /12 га талбайд /
4	Усны хайгуулын шинжилгээ хийх	Худгийн өрөмдлөгийн ажил эхлэхээс өмнө захиалагчтай харилцан зөвшилцсөний дагуу тодорхойлсон цэгт усны хайгуулын ажлыг хийж гүйцэтгэнэ.
5	Гүний худаг гаргах ажлыг гүйцэтгэх	Худаг гаргах ажилд хэрэглэгдэх материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн ашиглалтын шаардлага хангасан байна.
		Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавигдах шаардлага стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг гүйцэтгэх
		Зураг төсөв нь худгийн барилга, өрөмдлөг, гадна цахилгааны ажил гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.
		Ажлын явцад техник хяналтыг тогтмол хийлгэж, холбогдох актуудыг үйлдэх/хайгуул, өрөмдлөг, шавхалт г.м/, ажил дуусахад талбайг цэвэрлэх, ашиглагчид худгийн эзэмшил ашиглалтын талаар сургалт хийх
6	Паспорт, гэрчилгээжүүлэх	Чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулах (Ундны усанд ашиглах боломжтой шинжилгээний хариу шаардлагатай)
		Худгийн паспортыг гаргах/техникийн паспортыг хөтөлж аймгийн БОАЖГазраар баталгаажуулан хүлээлгэн өгөх
7	Санамж	Гүний худгийг батлагдсан зураг, төсвийн хүрээнд ажлыг хийж гүйцэтгэнэ. Зураг төсөл дээрх хэмжээг ажлын талбай дээр нягтлан шалгана. Хэрэв хэмжээний зөрүү гарсан тохиолдолд зураг, төслийн байгууллага болон захиалагчид мэдэгдэнэ.
8	Баталгаа	Ажил гүйцэтгэж хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд чанарын баталгаа шаардана.

9	Санхүүжилт	60,000,000 төгрөг
10	Урьдчилгаа	Санхүүжилтийн урьдчилгаа олгохгүй

Хянасан:Хонгор сумын Засаг даргын Орлогч Т.Нинжбадам

Боловсруулсан: Эмтнаран ОНӨААТҮГазрын УХАТ-ын инженер У.Мөнх-Учрал